



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/24

Модот

Лавлагаа шатлалын эрүүл мэндийн
Байгууллагад үйлчлүүлэгчийг илгээх,
шилжүүлэх, хүлээлцэх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/813 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн лавлагаа шатлалын эмнэлэгт өвчтөн илгээж, шилжүүлэх, хүлээлцэх журмыг хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдлөг болгон ажиллахыг эмч ажилчдад даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын багийн ахлагч (П.Хандармаа)-д үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ ИХ ЭМЧ



Г.ОЮУНБИЛЭГ